




САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

# ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2015 ОНЫ II УЛИРАЛ

**(Ажлын баримт)**



## Ажлын баримт – Дэлгэрэнгүй хэлбэрээр

Сүүлд шинэчлэгдсэн 2015.08.14

Танилцсан:

СЗХ-НЫ ДАРГА З.НАРАНТУЯА \_\_\_\_\_

СЗХ-НЫ ДЭД ДАРГА Х.БУМ-ЭРДЭНЭ \_\_\_\_\_

СЗХ-НЫ ДЭД ДАРГА Э.БАТБОЛД \_\_\_\_\_

Хянасан:

СЗХ-НЫ АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Б.БАТСЭЛЭНГЭ \_\_\_\_\_

ҮЦЗГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН

ГҮЙЦЭТГЭГЧ Т.ГАНДУЛАМ \_\_\_\_\_

ҮЦЗГ-ЫН ОРЛОГЧ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН

ГҮЙЦЭТГЭГЧ С.ТУЛГАА \_\_\_\_\_

ҮЦЗГ-ЫН ҮЦБХ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН

ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЭНХБАТ \_\_\_\_\_

Боловсруулсан:

ҮЦЗГ-ЫН ҮЦБХ-ЫН ХЯНАН

ШАЛГАГЧ Т.ИЧИННОРОВ \_\_\_\_\_

## I. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Манай улсын хувьд урт хугацааны эдийн засгийн өсөлтийг хангах, дотоодын эрэлтэд суурилсан салбарууд болох хөдөө аж ахуй, барилга, үл хөдлөх хөрөнгө, аялал жуулчлалыг төрөлжүүлэн хөгжүүлэх зайлшгүй шаардлага үүсээд байна.

Үнэт цаасны зах зээл нь олон нийтээс санхүүжилт босгохоор хувьцаа, өрийн хэрэгслээ мэргэжлийн зуучлагчаар дамжуулан зах зээлд гаргадаг нийлүүлэлтийн тал, ногдол ашиг болон ханшны зөрүүнээс ашиг олох зорилго бүхий хөрөнгө оруулагч буюу эрэлтийн тал, эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангаж, үнэ ханшийг тогтоох үүрэг бүхий дэд бүтцээс бүрддэг нийлмэл тогтолцоо.

Мөн дэд бүтцийн байгууллагуудын хоорондын уялдааг хангах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, нэгдсэн бодлого, дүрэм журмаар зохицуулах чиг үүргийг төрийн зохицуулагч байгууллага хэрэгжүүлдэг ба олон нийтийн болон хөрөнгө оруулагчийн боловсролыг дээшлүүлэх нь мөн тэргүүлэх чиглэлийн нэг болоод байгаа билээ.

Манай улсын үнэт цаасны зах зээл үүсэн бий болоод даруй 20 жилийн нүүрийг үзсэн боловч олон улсын болон бүс нутгийн интеграцид нэгдээгүй, дэд бүтцийн байгууллагуудын уялдаа сул, өмч хувьчлалын арга хэрэгсэл хэлбэрээр анхлан үүссэн тул компанийн засаглал сул, мэдээлэл, тайлагналын ил тод байдлын тогтолцоо бүрдээгүй байна.

### 1.1. Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн болон үндсэн үзүүлэлтүүд:

#### Зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар:

Зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 163.8 тэрбум төгрөгөөр буюу 10.41 хувиар буурч, 1 их наяд 480.5 тэрбум төгрөг болсон байна. Зах зээлийн үнэлгээ өндөр 30 компанийн үнэлгээ нийт зах зээлийн үнэлгээний 92.2 хувийг эзэлж байна.

Хөрвөх чадварын түвшин нь зах зээлд арилжигдаж буй үнэт цаасны эргэлтийг хэмжигч үзүүлэлт бөгөөд хөгжингүй зах зээлтэй орнуудын хувьд дээрх үзүүлэлт 0.80-0.90 хувь байдаг ба манай орны хувьд хөрвөх чадварын түвшин 0.004 хувь байгаа нь хувьцааны арилжаа зогсонги, эргэцгүйг илтгэж байна.


Зах зээлийн үнэлгээ буурахад эдийн засгийн өсөлт удааширсан, уул уурхайн салбарын компанийн хувьцааны үнэ ханш дотоодын болон олон улсын хөрөнгийн бирж дээр огцом буурсан, гадаадын хөрөнгө оруулагчдын үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулах сонирхол 2012 оноос хойш эрс буурсан, зах зээлийн дэд бүтэц сул зэрэг нь голчлон нөлөөлжээ.

Хүснэгт-1

Огноо	Зах зээлийн үнэлгээ /сая ₮/	ДНБ /сая ₮/	ЗЗҮ/ДНБ /хувиар/	Хөрвөх чадвар	Арилжааны хэмжээ /сая ₮/
2008/2nd Q	809 669.40	2 937 452.00	0.28	0.053	43 079.31
2009/2nd Q	471 412.80	2 810 214.40	0.17	0.022	10 294.17
2010/2nd Q	768 405.20	1 674 571.54	0.46	0.020	15 175.93
2011/2nd Q	1 991 133.00	5 989 819.63	0.33	0.023	46 333.01
2012/2nd Q	1 895 195.50	7 735 811.85	0.24	0.032	60 887.89
2013/2nd Q	1 437 737.30	8 585 373.70	0.17	0.009	12 305.66
2014/2nd Q	1 572 314.20	9 918 756.30	0.16	0.008	12 910.50
2015/2nd Q	1 408 502.50	10 689 994.90	0.13	0.004	5 725.84

Нийт зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 163.8 тэрбум төгрөгөөр буюу 10.42 хувиар буурч, 1 их наяд 408.5 тэрбум төгрөг болсон байна.

График-1

**Хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй 30 компани**

“Монголын хөрөнгийн бирж” ХК-нд бүртгэлтэй, хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй 30 компанийг жагсаавал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт-2

№	Үнэт цаасны нэр	Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/
1	АПУ	278.5
2	ТАВАН ТОЛГОЙ	204.6
3	ГОВЬ	78.01
4	ШАРЫН ГОЛ	74.79
5	ШИВЭЭ ОВОО	73.81
6	БАГАНУУР	67.12
7	БЭРХ УУЛ	57.19
8	УБ БҮК	45.13
9	СҮҮ	37.19
10	МОНГОЛ СЕКЬЮРИТИЕС	36
11	БИДИСЕК	31.45
12	МОН.ЦАХИЛГААН ХОЛБОО	25.82
13	БАЯНГОЛ ЗБ	20.73
14	МАТЕРИАЛИМПЕКС	20.73
15	ТАЛХ ЧИХЭР	19.96
16	ДАРХАН НЭХИЙ	19.9
17	ГУТАЛ	19.59
18	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	18.04
19	ХӨХ ГАН	14.39
20	ТАХЬ КО	13.08
21	МАХИМПЕКС	12.16
22	АТАР ӨРГӨӨ	11.84
23	ГЕРМЕС ЦЕНТР	11.7
24	СИЛИКАТ	10.43
25	ЖЕНКО ТУР БЮРО	9.85
26	АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС	10.29
27	АРИГ ГАЛ	8.18
28	АВТОИМПЕКС	7.59
29	МОГОЙН ГОЛ	6.6
30	МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС	6.45
<b>Нийт</b>		<b>1,249.48</b>
<b>Нийтэд эзлэх хувь</b>		<b>88.71</b>


Хөрвөх чадварын түвшинг бага байхад голчлон хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын хяналтын багц цөөн тооны хөрөнгө оруулагчдын гарт төвлөрсөн, нийт бүртгэлтэй компаниудын дийлэнх нь 75 хувиас дээш төвлөрөлтэй, нэмж үнэт цаас гаргах сонирхол бага, гадаад, дотоодын томоохон мэргэжлийн хөрөнгө оруулагч байхгүй, тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл дутмаг, хөрөнгийн бирж дээр маркет макерийн зуучлалын тогтолцоо хөгжөөгүй нь суурь нөлөөг үүсгэжээ. Мөн мэргэжлийн зуучлагч байгууллагуудын санхүүгийн болон хүний нөөцийн чадавхи сул, маржин арилжаа буюу зээлээр үнэт цаас худалдан, худалдан авах үйлчилгээний төрөл хөгжөөгүй байгаа зэрэг нь хөрвөх чадварын түвшинг бага байхад давхар нөлөөлж байна.

### Нийт арилжаа:

2015 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар нийт 125 удаагийн арилжаа явагдаж, 6 349 хэлцлээр нийтдээ 290.6 тэрбум төгрөгийн 19.3 сая ширхэг үнэт цаас арилжаалагдсан байна. Үүнээс 105 компанийн 16.4 сая ширхэг хувьцааг 5.7 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн 25 удаагийн арилжаагаар 2.9 сая ширхэг үнэт цаасыг 283.4 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 15.1 мянган ширхэг үнэт цаасыг 1.5 тэрбум төгрөгөөр тус тус арилжсан байна.

Нийт гүйлгээний үнийн дүнгийн 1.97%-ийг хувьцааны арилжааны гүйлгээний дүн, 98.03%-ийг ЗГҮЦ-ны арилжааны гүйлгээний дүн тус тус эзэлж байна.

График-2



Тайлант хугацаанд өдөрт дунджаар 2.3 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 154.6 мянган ширхэг үнэт цаас арилжигдсан байна. 2015 оны 2-р улирлын байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжаагаар “Бинсэ” ХК-ийн 112,205.616 төгрөгийн 150,814 ширхэг хувьцаа арилжигджээ.

2015 оны эхний хагас жилд хувьцааны арилжаа 2014 оны мөн үеэс 22.5 дахин их арилжаа хийгдсэн боловч нийт арилжааны 98.03 хувийг Засгийн газрын үнэт цаасны арилжаа эзэлж байна. 2011-2015 онуудын хагас жилээрх арилжааны хэмжээ, арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг болон хэлцлийн тоог хүснэгтлэн харуулбал доорх байдалтай байна. Үүнд:

Хүснэгт-3

Хугацаа	Хэлцлийн тоо	Үнэт цаас /ширхэг/	Арилжааны дүн /сая төгрөг/	Арилжааны дүнгийн өөрчлөлт /өмнөх оны мөн үетэй харьцуулахад/
2011 оны эхний хагас жил	25 823	69 751 673	82 333.0	-
2012 оны эхний хагас жил	21 817	108 188 214	61 198.1	-25.67%
2013 оны эхний хагас жил	8 449	21 976 815	12 305.6	-79.89%
2014 оны эхний хагас жил	8 422	29 992 501	12 910.5	4.92%
2015 оны эхний хагас жил	6 349	19 325 495	290 600.5	2150.88%

График-3




**Хувьцааны арилжаа:**

2015 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-д нийт 125 удаагийн хувьцааны арилжаа явагдаж, 6 349 хэлцлээр нийтдээ 105 компанийн 16.4 сая ширхэг хувьцааг 5.7 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна.

Хүснэгт-4

№	Он	Арилжигдсан хувьцааны тоо ширхэг	Арилжигдсан үнийн дүн
1	2008 II улирал	97 052 180	43 079 314 336.00
2	2009 II улирал	49 895 363	10 294 174 856.00
3	2010 II улирал	30 275 904	15 175 925 033.00
4	2011 II улирал	69 391 673	46 333 005 317.00
5	2012 II улирал	108 157 236	60 887 891 004.00
6	2013 II улирал	21 976 815	12 305 658 627.78
7	2014 II улирал	29 992 501	12 910 504 201.47
8	2015 II улирал	16 376 533	5 725 843 098.69

График-4



2015 оны эхний хагас жилд “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар 5 725 843 098.69 төгрөгийн хувьцааны арилжаа явагдсан бөгөөд 2013 оны мөн үетэй харьцуулахад 53.47 хувиар буюу 6 579 815 529.09 төгрөгөөр, 2014 оны мөн үетэй харьцуулахад 55.65 хувиар буюу 7 184 661 102.78 төгрөгөөр тус тус буурсан байна.

Хувьцааны арилжааны хэмжээ өмнөх онуудаас эрс буурахад голчлон гадаадын иргэн, аж ахуйн нэгжүүд манай орны бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцааг худалдан авах сонирхол буурсан, дийлэнх хувьцаат компаниудын засаглал сул, төвлөрөл өндөр, тайлагналын ил тод тогтолцоо төлөвшөөгүй, зах зээлийн хөрвөх чадвар доогуур байгаа нь нөлөөлжээ.

Мөн иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг, мэдээлэл хомсоос гадна хувьцаа худалдан авахаасаа илүүтэйгээр банкны хадгаламж, засгийн газрын үнэт цаасанд хөрөнгөө байршуулах сонирхол өндөр, хувьцаат компаниудын засаглалд итгэх итгэл сул байгаа нь давхар нөлөөлж байна.

Улсын бүртгэлд бүртгэлтэй байгаа дийлэнх аж ахуйн нэгжүүдийн өмчлөл нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр байгуулагдсан, гэр бүлийн бизнесийн шинжийг агуулсан, дутагдалтай байгаа санхүүжилтээ үнэт цаас гаргах замаар олон нийтээс хөрөнгө татан, төвлөрүүлэх сонирхол бага, банкны богино хугацаат зээлийн санхүүжилтийг чухалчлах хандлага давамгайлж байна. Энэ нь анхдагч зах зээлийн арилжаа болон компанийн бондын зах зээлийг хөгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. Санхүүгийн суурь хэрэгслүүдийн чадавхи сул байгаа нь эргээд үүсмэл санхүүгийн хэрэгсэл бий болох боломжийг багасгаж байна.

## Идэвхитэй арилжигдсан 30 үнэт цаас

Идэвхитэй арилжигдсан 30 үнэт цаасны тоо ширхэг нь нийт арилжигдсан хувьцааны тоо ширхэгийн 98.95 хувь, нийт үнийн дүнгийн 92.20 хувийг тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд 105 компанийн үнэт цаас арилжигдсанаас өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32 компанийн үнэт цаасны ханш өсч, 57 компанийн үнэт цаасны ханш буурч, 12 компанийн үнэт цаасны ханш тогтмол байна.

## Хүснэгт-5

ҮНЭТ ЦААС	АРИЛЖИГДСАН ШИРХЭГ	Эрэмбэ	ҮНЭТ ЦААС	ҮНИЙН ДҮН
Э- ТРАНС ЛОЖИСТИКС	5,700,372	1	АПУ	653,270,012
ХӨХ ГАН	4,441,757	2	Э- ТРАНС ЛОЖИСТИКС	574,918,009
МЕРЕКС	1,514,968	3	ХӨХ ГАН	506,883,420
ХОРИНХОЁРДУГААР БААЗ	1,318,569	4	БИДИСЕК	458,330,367
ГЕРМЕС ЦЕНТР	634,858	5	ТАЛХ ЧИХЭР	416,145,510
РЕМИКОН	560,503	6	МАТЕРИАЛИМПЕКС	354,611,830
БИДИСЕК	261,109	7	ТАВАН ТОЛГОЙ	338,666,006
БИНСЭ ХК	196,331	8	ХОРИНХОЁРДУГААР БААЗ	270,306,645
АПУ	182,208	9	ГОВЬ	195,037,565
ГОНИР	160,332	10	БИНСЭ ХК	148,616,070
УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	157,384	11	МЕРЕКС	138,878,659
ЖЕНКО ТУР БЮРО	154,580	12	МОНГОЛ КЕРАМИК	108,461,675
ОЛЛОО	110,579	13	ЕВРОФЁ АЗИА	97,349,000
ӨНДӨРХААН	91,443	14	ДАРХАН НЭХИЙ	93,185,360
ЖИНСТ УВС	90,056	15	ГЕРМЕС ЦЕНТР	89,117,528
ТАВАН ТОЛГОЙ	80,213	16	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	84,005,825
МОНГОЛ САВХИ	69,413	17	БАЯНГОЛ ЗБ	79,043,450
БАЯЛАГ НАЛАЙХ	64,383	18	МОНГОЛ САВХИ	69,369,765
ХАЙ БИ ОЙЛ	61,662	19	ШАРЫН ГОЛ	64,848,906
МОНГОЛ МАХ ЭКСПО	59,252	20	ДОРНОД АВТОЗАМ	64,732,500
БИШРЭЛТ ИНДАСТРИЛ	54,611	21	МОНГОЛ МАХ ЭКСПО	58,279,059
МОНИНЖБАР	53,753	22	ГУТАЛ	53,818,860
ЕВРОФЁ АЗИА	30,400	23	МАХИМПЕКС	51,559,451
ХӨВСГӨЛ ХҮНС	28,732	24	УБ БҮК	49,741,400
ГОВЬ	24,475	25	ЖИНСТ УВС	48,417,708
ДОРНОД АВТОЗАМ	23,975	26	РЕМИКОН	45,902,764
МАТЕРИАЛИМПЕКС	23,065	27	БАГАНУУР	43,973,941
ТАЛХ ЧИХЭР	22,831	28	БАЯЛАГ НАЛАЙХ	42,794,798
БАГАНУУР	16,905	29	БИШРЭЛТ ИНДАСТРИЛ	39,629,856
ЖАРГАЛАНТ ҮЙЛС	15,700	30	СҮҮ	39,264,300
<b>Нийт</b>	<b>16,204,419</b>			<b>5,279,160,238</b>
<b>Нийтэд хувьцааны арилжаанд эзлэх хувь</b>	<b>98.95</b>			<b>92.20</b>

## Ханшийн өсөлттэй 20 үнэт цаас

Хүснэгт-6

№	Үнэт цаас	Хаалтын ханш 2014.06.30	2015.06.30	Ханшийн өөрчлөлт /төг/	Өөрчлөлт хувиар
1	МОНИТ БУЛИГААР	6,200.00	10,000.00	3,800.00	61.29
2	ТАВ	19,500.00	30,000.00	10,500.00	53.85
3	ГОВЬФАЙНЕНШИЛ ГРУПП	339.29	509	169.71	50.02
4	ГАЗАР СҮЛЖМЭЛ	39,000.00	54,000.00	15,000.00	38.46
5	ЕВРОАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ	18	24.33	6.33	35.17
6	ДАРХАН ХҮНС	3,712.00	5,000.00	1,288.00	34.7
7	ТЕХНИКИМПОРТ	695	919.13	224.13	32.25
8	ХӨХ ГАН	110	142	32	29.09
9	ГОВЬ	7,850.00	10,000.00	2,150.00	27.39
10	БИНСЭ ХК	586.9	730	143.1	24.38
11	ХӨСӨГ ТРЕЙД	1,139.00	1,400.00	261	22.91
12	ОРХОН ДАЛАЙ	3,300.00	3,990.00	690	20.91
13	МОНГОЛ ШЕВРО	2,640.00	3,174.00	534	20.23
14	АРИГ ГАЛ	2,015.00	2,350.00	335	16.63
15	ДАРХАН НЭХИЙ	15,600.00	18,000.00	2,400.00	15.38
16	ХАЙ БИ ОЙЛ	390	449.63	59.63	15.29
17	ХӨВСГӨЛ ХҮНС	591.15	680	88.85	15.03
18	ХӨВСГӨЛ	43.71	50.26	6.55	14.99
19	ХАСУ МАНДАЛ	3,600.00	4,100.00	500	13.89
20	БҮТЭЭЛЧ ҮЙЛС	795	900	105	13.21

## Ханшийн бууралттай 20 үнэт цаас

Хүснэгт-7

№	Үнэт цаас	Хаалтын ханш 2014.06.30	2015.06.30	Ханшийн өөрчлөлт /төг/	Өөрчлөлт хувиар
1	ТҮШИГ УУЛ	3,200.00	330	-2,870.00	-89.69
2	МОНГОЛ МАХ ЭКСПО	6,125.00	1,550.00	-4,575.00	-74.69
3	ЧАЦАРГАНА	3,308.00	1,000.00	-2,308.00	-69.77
4	БИШРЭЛТ ИНДАСТРИЛ	4,500.00	1,600.00	-2,900.00	-64.44
5	РЕМИКОН	150	78	-72	-48
6	МОГОЙН ГОЛ	15,000.00	7,950.00	-7,050.00	-47
7	БӨӨНИЙ ХУДАЛДАА	800	430	-370	-46.25
8	ИХ БАРИЛГА	7,800.00	4,800.00	-3,000.00	-38.46
9	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	800	505	-295	-36.88
10	МОНГОЛ НЭХМЭЛ	5,300.00	3,364.00	-1,936.00	-36.53
11	ХИШИГ УУЛ	1,020.00	650	-370	-36.27
12	МОНИНЖБАР	290	185	-105	-36.21
13	ГУРИЛ ТЭЖЭЭЛ БУЛГАН	3,500.00	2,300.00	-1,200.00	-34.29
14	НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ	1,800.00	1,200.00	-600	-33.33
15	МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС	699	469	-230	-32.9
16	МОН.ЦАХИЛГААН ХОЛБОО	1,460.00	998	-462	-31.64
17	БИДИСЕК	2,680.00	1,850.00	-830	-30.97
18	БЛЮ СКАЙ СЕКЬЮРИТИС	3,100.00	2,150.00	-950	-30.65

19	МОННООС	4,600.00	3,240.00	-1,360.00	-29.57
20	МОНГОЛ ШИЛТГЭЭН	896	640	-256	-28.57

### Засгийн газрын үнэт цаасны арилжаа:

2014 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хооронд “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар ЗГҮЦ арилжигдаж эхэлснээс хойш нийт 319.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 3.3 сая ширхэг үнэт цаас анхдагч зах зээл дээр арилжигдаад байна. Мөн урт хугацаат буюу 3 жилийн хугацаат ЗГҮЦ-ыг 2015 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн МХБ-ээр дамжуулан арилжиж эхлээд байна.

#### Анхдагч зах зээлийн арилжаа:

2015 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар авч үзвэл 25 удаагийн ЗГҮЦ-ны арилжаагаар нийт 2.9 сая ширхэг ЗГҮЦ-ыг 283.4 тэрбум төгрөгөөр арилжаад байна.

Тайлант хугацаанд анхдагч зах зээл дээр нийт 283.4 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжигдсанаас 12 долоо хоногтой ЗГҮЦ-ны арилжаа дийлэнхи хувийг буюу 89.05%-ийг, 28 долоо хоногтой үнэт цаас 5.64%, 52 долоо хоногтой үнэт цаас 5.30%, 3 болон 5 жилийн урт хугацаатай үнэт цаас нийт арилжааны 0.01%-ийг тус тус эзэлж байна.

Анхдагч зах зээлийн арилжаа эрчимтэй хөгжихгүй байгаад дараахь хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд: Үнэт цаасны зах зээлийн багтаамж бага, иргэдийн тус зах зээлд итгэх итгэл сул, илүүдэл мөнгөн хөрөнгөө банкны хадгаламжид байршуулах сонирхол өндөр, андеррайтерийн компаниудын чадавхи сул, мэргэжлийн томоохон хөрөнгө оруулагчид байхгүйгээс шалтгаалан санхүүжүүлэхээр зорьж буй хөрөнгийг бүрэн татан төвлөрүүлэх боломж хомс байна.

#### Хоёрдогч зах зээлийн арилжаа:

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааг 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр нээсэн бөгөөд тайлант хугацаанд нийт 15.1 мянган ширхэг үнэт цаас 1.5 тэрбум төгрөгөөр арилжигдсан.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааг идэвхжүүлэх үүднээс 2015 оны 2 дугаар сараас эхлэн “Market makers” буюу итгэмжлэгдсэн дилерийн тогтолцоог нэвтрүүлж өнөөдрийн байдлаар нийт 4 ҮЦК итгэмжлэгдсэн дилер эрхээ авч, улмаар хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 15.1 мянган ширхэг үнэт цаас арилжиж, нийт 1.5 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаанд “Ард капитал”, “Голомт секьюритиз”, “Дэү секьюритиз”, “Гацуурт трейд”, “БиДиСек”, “Стандарт инвестмент”, “Блюмсбюри секьюритиз” зэрэг ҮЦК-иуд идэвхитэй оролцсон байна.

### Багцын арилжаа:


Тайлант хугацаанд 13 удаагийн багцын арилжаагаар нийт 13 компанийн 11.1 сая ширхэг хувьцааг 1.5 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 26.78%-ийг эзэлжээ.

### Тендер саналын арилжаа:

Тайлант хугацаанд 1 удаагийн тендер саналын арилжаа явагдаж, “Монголын хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн 202 ширхэг хувьцааг 711.4 мянган төгрөгөөр арилжсан байна.

**Топ-20 индекс:**

График-5



Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 15737.17, доод үзүүлэлт 12477.28, дундаж үзүүлэлт 13744.84 нэгж байх бөгөөд ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 464.65 нэгжээр буюу 3.00 хувиар буурч, 15023.81 нэгж болжээ.

**MSE ALL индекс:**

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь 2015 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн MSE ALL индексийг албан ёсоор тооцож эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд MSE ALL индексийн дээд үзүүлэлт нь 1057.86, доод үзүүлэлт нь 921.67, дундаж үзүүлэлт 971.20 нэгж байв. 2015 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар 1025.89 нэгжид хүрчээ.

Тайлант хугацаанд Засгийн газрын үнэт цаасны арилжаанаас бусад үзүүлэлтүүд буурсан байх бөгөөд энэхүү бууралтад хувьцааны арилжаа хэмжээ эрс буурсан нь эргээд зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, ТОП-20 индексийн өөрчлөлтөд шууд нөлөө үзүүлсэн гэж дүгнэхээр байна. Хувьцааны арилжааны хэмжээ эрс буурахад гадаад дотоод орчны дараах хүчин зүйлс нөлөөлжээ.

График-6



### Шигтгээ-1:

- Гадаад болон дотоодын хөрөнгийн биржид бүртгэлтэй байгаа үндэсний уул уурхайн компаниудын хувьцааны үнэ ханшийн бууралт, хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьцааны төвлөрөл;
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын эрэлт, хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон тэдгээрийн нийлүүлэлтийн дутагдал;
- Зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын сул байдал, хувьцаат компаниудын засаглал, мэдээллийн болон санхүүгийн тайлагналын ил тод нээлттэй тогтолцоо бүрдээгүй;
- Хувьцааны үнэ ханшид дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох, зах зээлийг урвуулан ашиглаж нөлөөлөх хандлага өндөр;
- Олон нийтийн санхүүгийн болон хөрөнгө оруулалтын боловсрол сул, үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийхээсээ илүүтэйгээр банкны хадгаламжид байрилуулах сонирхол өндөр.

### Үнэт цаасны мөнгөн хөрөнгийн гүйлгээ:

Тайлант хугацаанд төвлөрсөн хадгаламжийн дансаар 2015 оны эхний хагас жилд нийт 389 харилцагчийн дансанд 1666 удаа 1 437 413.7 сая төгрөгийн орлогын гүйлгээ, 1980 харилцагч 2638 удаа 1 436 941.3 сая төгрөгийн зарлагын гүйлгээ, нийт 2369 харилцагчийн дансанд 4304 удаа 2 874 355.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийгдсэн байна. Үүнд:

- “ҮЦТТТХТ” ХХК банкаар нийт 1102 удаа 1 435 627.9 сая төгрөгийн орлогын гүйлгээ хийгдсэн. Үүнээс их дүнтэй 635 удаа 1 435 510.3 сая төгрөг, харин бага дүнтэй 467 удаа 117.5 сая төгрөгийн орлогын гүйлгээ;
- “ҮЦТТТХТ” ХХК банкаар 2605 удаа 1 436 628.5 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн. Үүнээс их дүнтэй 665 удаа 1 436 360.3 сая төгрөг, харин бага дүнтэй 1940 удаа 268.2 сая төгрөгийн зарлагын гүйлгээ;
- Төрийн банкаар 597 удаа 2 098.6 сая төгрөгийн орлого зарлагын гүйлгээ хийгдсэнээс орлогын гүйлгээ 564 удаа 1 785.8 сая төгрөг харин 33 удаа 312,8 сая төгрөгийн зарлагын гүйлгээ тус тус хийгдсэн байна.

2015 оны 2 дугаар улирлын байдлаар “ҮЦТТТХТ” ХХК нь 3 удаа 1 132.5 сая төгрөгийн зузаатгалын гүйлгээ хийсэн байх бөгөөд Төрийн банкны тусгай гэрээт данснаас “ҮЦТТТХТ” ХХК-ийн 3603005 дансанд, “ҮЦТТТХТ”-ийн 3603005 данснаас Төрийн банкны 341300035807 дансанд хийгдсэн гүйлгээ байна.

### Мөнгөн хөрөнгийн орлогын гүйлгээ

Хүснэгт-8

Хугацаа	Тоо	Үнийн дүн /сая төгрөг/
2011 оны эхний хагас жил	4 345	107 652.1
2012 оны эхний хагас жил	5 165	120 685.7
2013 оны эхний хагас жил	920	607 984.0
2014 оны эхний хагас жил	1 059	713 596.3
2015 оны эхний хагас жил	1 666	1 437 413.7

График-7



Хүснэгт-9

Хугацаа	Тоо	Үнийн дүн /сая төгрөг/
2011 оны эхний хагас жил	6 447	100 342.90
2012 оны эхний хагас жил	7 205	102 235.60
2013 оны эхний хагас жил	2667	625 512.80
2014 оны эхний хагас жил	1 833	720 656.70
2015 оны эхний хагас жил	2 638	1 436 941.30

### Мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээ

2015 оны эхний хагас жилд нийт орлого зарлагын гүйлгээний дүн 2014 оны мөн үеэс 2 дахин их, 2013 оны мөн үеэс 2.3 дахин их, 2012 оны мөн үеэс 12.8 дахин, 2011 оны мөн үеэс даруй 13.8 дахин их үзүүлэлттэй байна.


График-8



### Төлбөр гүйцэтгэгч банкуудаар хийгдсэн гүйлгээний дүн, банк тус бүрээр:

2015 оны эхний хагас жилд төлбөр гүйцэтгэх 4 банкаар нийт 2 925.7 сая төгрөгийн арилжааны төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: Хасбанк 1 144.0 сая, Голомт банк 1 059.0 сая, Худалдаа Хөгжлийн банк 671.4 сая, Хаан банк 51.3 сая төгрөгийн гүйлгээг тус тус хийсэн байна.

График-9



### Нийт хувьцааны гүйлгээний дүнд түүнд дотоод, гадаад иргэдийн эзлэх хувь:

2015 оны эхний хагас жилд арилжааны үнийн дүнд гадаад аж ахуйн нэгжийн эзлэх хувь 2014 оны мөн үетэй харьцуулахад 8.0 хувиас 0.72 хувь болж буурсан бөгөөд дотоодын аж ахуйн нэгжийн арилжааны үнийн дүнд эзлэх хэмжээ 38.0 хувиас 92.2 хувь болж өссөн. Гэхдээ гадаад иргэний арилжааны үнийн дүнд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 9.0 хувиас 0.77 хувь болж буурсан бол дотоодын иргэн 45.0 хувиас 6.2 хувь болж буурсан байна.

График-10



### Арилжааны шимтгэлийн тухай:

2015 оны эхний хагас жилд 290.6 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж нийт 509.9 сая төгрөгийн шимтгэл тооцогдсон байна.

Хүснэгт-10

Хугацаа	МХБ	ҮЦТТТХТ	СЗХ	БДК	Нийт
2011 оны эхний хагас жил	330.1	201.4	198.2	1252.6	1982.3
2012 оны эхний хагас жил	395.8	263	206.5	1199.9	2065.3
2013 оны эхний хагас жил	89.1	59.3	20.2	-	168.6
2014 оны эхний хагас жил	84	55.4	25.4	-	164.8
2015 оны эхний хагас жил	384.5	40.4	23.3	61.7	509.9

График-11



Тайлант хугацаанд тооцогдсон нийт 509.9 сая төгрөгийн шимтгэлийг 2013 оны мөн үетэй харьцуулахад 3.02 дахин буюу 341.3 сая төгрөгөөр, 2014 оны мөн үетэй харьцуулахад 3.09 дахин буюу 345.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Арилжааны хэмжээ өмнөх онуудаас эрс нэмэгдэхэд голчлон ЗГҮЦ-ны шимтгэлийн өсөлт нөлөөлжээ. Мөн иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг, мэдээлэл хомсоос гадна хувьцаа худалдан авахаасаа илүүтэйгээр банкны хадгаламж, засгийн газрын үнэт цаасанд хөрөнгөө байршуулах сонирхол өндөр, хувьцаат компаниудын засаглалд итгэх итгэл сул байгаа нь давхар нөлөөлж байна.

### Үнэт цаасны хадгаламж

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид 2015 оны эхний хагас жилийн байдлаар 319 хувьцаат компанийн 1.4 их наяд төгрөгийн зах зээлийн үнэлгээ бүхий 20 045 372 960 ширхэг үнэт цаас хадгалагдаж байгаагаас төрийн өмчтэй 36 хувьцаат компанийн 14 690 873 659 ширхэг хувьцаа, орон нутгийн өмчтэй 9 хувьцаат компанийн 29 045 916 ширхэг хувьцаа байна.

Төвлөрсөн хадгаламжид нийт 20 төрлийн 15 927 261 ширхэг компанийн бонд, 103 төрлийн 4 925 402 ширхэг Засгийн газрын бонд тус тус бүртгэлтэй байна. Үүнээс: 16 төрлийн 15 694 297 ширхэг компанийн бонд, 55 төрлийн 2 104 540 ширхэг Засгийн газрын бонд нь биржийн бус зах зээл буюу хаалттай хэлбэрээр бүртгэгдсэн байна.

Мөн “ҮЦТТТХТ” нь “Хөдөө аж ахуйн давхар даатгал” хаалттай ХК-ийн 150 000 000 ширхэг хувьцааг Хорооны 2014 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 160 дугаар тогтоолоор баталсан “Хаалттай ХК-ийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх эрх шилжүүлэх үйл ажиллагааны журам”-ын дагуу төвлөрсөн хадгаламжид бүртгэсэн байна.

Төрийн мэдлийн нийт 36 хувьцаат компанийн 16.2 тэрбум ширхэг хувьцаанаас “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй 35 хувьцаат компанийн 2 254 152 239 ширхэг хувьцаа, биржийн бус зах зээлд бүртгэлтэй 1 хувьцаат компанийн /“Эрдэнэс Тавантолгой” ХК/ 14 027 951 337 ширхэг хувьцаа байна.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэлтэй нийт 319 хувьцаат компанийн 20 045 372 960 ширхэг үнэт цаасыг төрийн өмчийн оролцоотой, орон нутгийн оролцоотой болон төрийн мэдлийн бусаар нь авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Төрийн өмчийн оролцоотой хувьцаа 14 690 873 659 ширхэг буюу нийт хувьцааны 73.29%-ийг, үүнээс нээлттэй 35 хувьцаат компанийн 2 524 152 239 ширхэг, хаалттай 1 хувьцаат компанийн 12 436 721 420 ширхэг хувьцаа;
- Орон нутгийн оролцоотой хувьцаа 29 045 916 ширхэг буюу нийт хувьцааны 0.14%-ийг;
- Төрийн мэдлийн бус хувьцаа 3 325 453 385 ширхэг буюу нийт хувьцааны 26.57%-ийг тус тус эзэлж байна.


Хүснэгт-11

Үзүүлэлт	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015.II он
<b>Бүртгэлтэй үнэт цаас</b>					
Төрийн мэдлийн бус хувьцаа	2 555 045.0	2 665 629.0	2 595 868.0	2 913 776.0	2 492 175.0
Төрийн мэдлийн хувьцаа	356 933.0	1 979 932.0	1 951 589.0	2 254 152.0	2 524 152.0
Орон нутгийн оролцоотой	29 128.0	29 046.0	29 046.0	29 046.0	29 046.0
<b>Нийт хувьцаа</b>	<b>2 941 106.0</b>	<b>4 674 607.0</b>	<b>4 576 503.0</b>	<b>5 196 974.0</b>	<b>5 045 373.0</b>
Засгийн газрын бонд	4 238.0	4 335.0	2 348.0	2 510.0	2 821.0
Компанийн бонд	3 233.0	693.6	233.0	233.0	233.0
<b>Нийт бондын тоо</b>	<b>7 471.0</b>	<b>5 028.6</b>	<b>2 581.0</b>	<b>2 743.0</b>	<b>3 054.0</b>
<b>Биржийн бус зах зээлд бүртгэлтэй үнэт цаас</b>					

Компанийн бонд	21.6	20.6	3 300.0	8 402.0	15 694.0
Засгийн газрын бонд	1 000.0	1 293.0	2 531.0	2 512.0	2 105.0
<b>Нийт бондын тоо</b>	<b>1 021.6</b>	<b>1 313.6</b>	<b>5 831.0</b>	<b>10 914.0</b>	<b>17 799.0</b>
Эрдэнэс Тавантолгой /Иргэн/		1 463 519.0	1 463 519.0	967 134.0	2 558 176.0
Эрдэнэс Тавантолгой /ААН/		16 692.0	5 046.0	4 915.0	5 103.0
Эрдэнэс Тавантолгой /Төр/	15 000 000.0	13 519 789.0	13 531 436.0	14 027 951.0	12 436 721.0
<b>Нийт</b>	<b>15 000 000.0</b>	<b>15 000 000.0</b>	<b>15 000 000.0</b>	<b>15 000 000.0</b>	<b>15 000 000.0</b>
ХАА-н давхар даатгал /хаалттай/ ХК	-	-	-	-	150 000 000.0
<b>Нийт</b>					<b>150 000 000.0</b>

Хадгалагдаж буй нийт үнэт цаасны тоо ширхэгийг дээрх 3 төрөлд хувьчлан график байгуулвал:

График-12



### Хөрөнгө оруулагчдын бүтэц:

Тайлант хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид шинээр 11 540 данс нэгдсэнээс Монгол улсын иргэн 11 482, гадаад улсын иргэн 34, Монгол улсын аж ахуй нэгж 23, гадаадын аж ахуйн нэгжийн 1 данс шинээр нээгдсэн байна. Төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр нийт 797 403 данс, холболтын 134 679 холболтын данс нээгдсэнээс Монгол иргэдийн 792 977, гадаад иргэдийн 1 769, Монголын аж ахуйн нэгжийн 2 456, гадаадын аж ахуйн нэгжийн 174 данс тус тус бүртгэлтэй байна.

Дээрх тоог хувилж үзвэл нийт нээгдсэн дансны 99 хувийг дотоодын иргэн, аж ахуйн нэгжийн данс эзэлж байгаа бол үлдсэн 1 хувийг л гадаадын иргэн, аж ахуйн нэгжийн данс эзэлж байна.

Хөрөнгө оруулагчдын хувьд хувьцаат компанийн 5 хувиас дээш хувийг эзэмшигч нийт 1 048 хувьцаа эзэмшигчийн эзэмшилд 19.3 тэрбум ширхэг хувьцаа төвлөрсөн байна. Энэ нь нийт бүртгэлтэй хувьцааны 96.7 хувийг эзэлж байна.

Хүснэгт-12

д/д	Хөрөнгө оруулагчдын бүтэц	Хувьцааны арилжааны үнийн дүн	Арилжаанд эзлэх хувь
1.	Гадаадын аж ахуйн нэгж	41.04 сая төгрөг	0.72%
2.	Гадаадын иргэн	43.89 сая төгрөг	0.77%
3.	Дотоодын аж ахуйн нэгж	5 255.4 сая төгрөг	92.2%
4.	Дотоодын иргэн	353.4 сая төгрөг	6.2%


### Өмчлөх эрх шилжүүлэх:

“ҮЦТТТХТ” ХХК нь 2015 оны 02 дугаар улиралд үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг шилжүүлэх гүйлгээг дараах байдлаар хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

Хүснэгт-13

№	Өмчлөх эрх шилжүүлэх	Гүйлгээний тоо	Үнэт цаасны тоо ширхэг	Шимтгэлийн дүн
1	Өв залгамжлал	347	190 081	3 633 974.54
2	Бэлэглэл	23	73 814	578 386.53
3	Шүүхийн шийдвэр	2	10 579	128 706.89
4	Нэмж гаргасан хувьцааг нэр заан эзэмшүүлэх	1	1 530 200	153 020.00
5	Хөрөнгөөр баталгаажсан бонд	45	11 536 721	57 683 605.00
6	ЗГҮЦ-ны төв банкны овернайт репо	194	1 612 410	115 834 226.09

График-13



### Өмчлөх эрхээр үүргийн гүйцэтгэл хангуулах:

2015 оны 02 дугаар улирлын байдлаар 16 харилцагчийн 7 төрлийн хувьцаат компанийн 29 901 848 ширхэг үнэт цаас 74.0 тэрбум төгрөгийн зээлийн барьцаанд, 17 харилцагчийн 10 хувьцаат компанийн 22 588 373 ширхэг үнэт цаас 124.3 сая ам.долларын зээлийн барьцаанд тусгаарлаж 52 862 034.40 төгрөгийн шимтгэл тооцсоноос “ҮЦТТТХТ” ХХК-ийн орлогод 42 289 627.52 төгрөгийг тооцсон байна.

Тайлант хугацаанд 15 харилцагчийн 11 хувьцаат компанийн 62.4 тэрбум төгрөгийн зээлийн барьцааны 1 404 585 ширхэг үнэт цаас чөлөөлөгдсөн бол 12 харилцагчийн 57.7 сая ам.долларын зээлийн барьцаанаас 21 437 137 ширхэг үнэт цаас тус тус чөлөөлөгдсөн байна.

2015 оны 02 дугаар улиралд хугацаанаас өмнө 2 хувьцаат компанийн зээл чөлөөлөгдөж 4 402 238.63 төгрөгийг буцаан шилжүүлж, 2 зээлдэгчийн хугацаа хэтэрсний шимтгэлд 2 532 776.97 төгрөгийг нэмж тооцсон байна.

Өнөөдрийн байдлаар 24 хувьцаат компанийн болон 1 Засгийн газрын бондын 53.1 сая ширхэг үнэт цаас 111.3 тэрбум төгрөгийн зээлийн барьцаанд, 14 хувьцаат компанийн болон 4 Засгийн газрын бондын 136.7 сая ширхэг үнэт цаас 192.3 сая ам.долларын зээлийн барьцаанд тус тус тусгаарлагдаж байна.

### Шигтгээ-2:

- *Олон улсын зах зээл дээрх түүхий эдийн үнэ хани унасантай холбоотойгоор уул уурхайн компаниудын үйл ажиллагаа, эдийн засгийн огцом өсөлт саарсан нь эргээд хөрөнгийн биржид бүртгэлтэй уул уурхайн компаниудын хувьцааны үнийг бууруулсан;*
- *Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын өмчлөх эрхийг баталгаажуулах кастодианы үйлчилгээ зах зээлд нэвтэрсэн боловч үйл ажиллагаа жигдрээгүй, тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл дутмаг;*
- *Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг арилжаанд оролцоход дэмжлэг үзүүлэх татварын таатай орчин бүрдээгүй;*
- *Зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын уялдаа холбоо сул, мэргэжлийн оролцогч байгууллагуудын гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг зах зээлд татах чадавхи сул.*

### 2.2. Үнэт цаас гаргагчдын бүтэц:

Хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК болон “ҮЦТТХТ” ХХК-д бүртгэлтэй үнэт цаас гаргагчдын бүтцийг үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Үнэт цаас гаргагч компанийн хэлбэр	Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй	Хүснэгт -14	
		“Монголын хөрөнгийн бирж” ХК-нд бүртгэлтэй	“ҮЦТТХТ” ХХК-д бүртгэлтэй
100% Төрийн өмчийн	32	19	19
Төрийн өмчийн оролцоотой	11	4	11
Орон нутгийн оролцоотой	15	9	15
Хувийн өмчийн	245	205	276
<b>Нийт</b>	<b>303</b>	<b>237</b>	<b>321</b>

2015 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Хороонд 303 компани бүртгэлтэйгээс 100 хувь төрийн өмчийн 32, төрийн өмчийн оролцоотой 11, орон нутгийн оролцоотой 15, хувийн өмчит 245 /үүнээс 90 хувьцаат компанийн арилжааг зогсоосон/ компани, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн бүртгэлд нийт 237 хувьцаат компани бүртгэлтэйгээс 100 хувь төрийн өмчийн 19, төрийн өмчийн оролцоотой 4, орон нутгийн оролцоотой 9, хувийн өмчит 205 компани бүртгэлтэй байгаа бол “ҮЦТТХТ” ХХК-ийн бүртгэлд нийт 321 хувьцаат компани бүртгэлтэй байгаагаас 100 хувь төрийн өмчийн 19, төрийн өмчийн оролцоотой 11, орон нутгийн оролцоотой 15, хувийн өмчит 276 компани бүртгэлтэй байна.

### Үнэт цаас гаргагчдын хуулийн хэрэгжилтийн талаар:

Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувийн өмчит компаниудын дийлэнх хувь нь өмч хувьчлалын үр дүнд үүсэн бий болсноос үүдэн компанийн хувьцааны хяналтын багц цөөн тооны нэгдмэл

сонирхолтой этгээдүүдийн гарт төвлөрч, зах зээлийн нийлүүлэлтийн талд дутагдалтай байдал үүсгээд байна.

Хувьцаат компанийн хяналтын багц цөөн тооны этгээдүүдийн гарт төвлөрсөн нь компанийн засаглалыг сул байлгах, дотоод мэдээлэл эзэмшигч этгээд үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхлыг бууруулж, зах зээлийн хөрвөх чадварыг бууруулах үндсэн шалтгаан болж байна. 2015 оны хагас жилийн байдлаар Хороонд бүртгэлтэй 303 хувьцаат компанийн 193 компани нь 75 ба түүнээс дээш хувийн төвлөрөлтэй байна.

Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны 2012 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” болон Хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-аар хувьцаат компаниудад хүлээлгэсэн үүргийн хэрэгжилтийн байдал нийт 303 ХК-ийн хувьд 2015 оны эхний хагас жилийн байдлаар дараахи байдалтай байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлээ ирүүлсэн компанийн тоо	Санхүүгийн тайлан ирүүлсэн компанийн тоо	Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан компанийн тоо	Ногдол ашиг хуваарилсан компанийн тоо
<b>НИЙТ 303 ХК</b>			
<b>145 ХК</b>	<b>177 ХК</b>	<b>133 ХК</b>	<b>23 ХК</b>
<b>47.85%</b>	<b>58.41%</b>	<b>43.89%</b>	<b>7.59%</b>

Харин Хороонд бүртгэлтэй нийт 303 хувьцаат компаниас үнэт цаасны арилжаа нь зогссон 90 хувьцаат компани, 100 хувь төрийн өмчийн 32, төрийн өмчийн оролцоотой 11 болон орон нутгийн оролцоотой 15 хувьцаат компанийг хасаад үлдсэн буюу “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар хувьцаа нь идэвхитэй арилжаалагддаг, хэвийн үйл ажиллагаатай 155 хувьцаат компанийн хувьд 2015 оны эхний хагас жилийн байдлаар хуулийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлээ ирүүлсэн компанийн тоо	Санхүүгийн тайлан ирүүлсэн компанийн тоо	Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан компанийн тоо	Ногдол ашиг хуваарилсан компанийн тоо
<b>Нийт 155 ХК</b>	<b>Нийт 213 ХК</b>	<b>Нийт 155 ХК</b>	<b>Нийт 213 ХК</b>
<b>145 ХК /93.54%/</b>	<b>177 ХК /83.09%/</b>	<b>133 ХК /85.80%/</b>	<b>23 ХК /10.79%/</b>

*Жич: Санхүүгийн тайлан ирүүлсэн тоо болон ногдол ашиг хуваарилсан компанийн тоонд зөвхөн арилжаа нь зогссон 90 хувьцаат компанийг хасаад нийт 213 компаниас хувийг тооцсон болно.*

2014 онд хувьцаа эзэмшигчдийн хурлаа зарлан хуралдуулахаар мэдэгдэл ирүүлсэн дээрх 145 хувьцаат компаниас 133 хувьцаат компани нь хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан байх бөгөөд тус Хорооны Хяналт шалгалтын газраас дээрх хувьцаат компаниудын хурлын материалыг холбогдох хууль, журмын дагуу тухай бүр хянаж, хурлын хариуг хүргүүлсэн байна.

### Үнэт цаас гаргагчдын санхүүгийн байдал:

Компанийн тухай хуулийн 95.2-д “Хувьцаат компанийн хувьд Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон нэмэлт, мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад тогтоосон хугацаанд нь хүргүүлэн нийтэд мэдээлэх үүрэгтэй гэж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.6-д “хагас жилийн болон Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Хороо болон хөрөнгийн биржид хүргүүлэх” гэж тус тус заасны дагуу 177 хувьцаат компани 2015 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлангаа тус Хороонд ирүүлсэн.

### Нийт хөрөнгийн бүтэц:

Санхүүгийн нэгтгэлд хамрагдсан 177 хувьцаат компанийн нийт хөрөнгө нь 4 132.93 тэрбум төгрөг байх бөгөөд тайлант улирлын байдлаар мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нийт хөрөнгийн 2.53 хувийг, авлага 9.29 хувийг, татвар, бусад санхүүгийн хөрөнгө 0,56 хувийг, бараа материал 11,08 хувийг, урьдчилж төлсөн зардал 11.19 хувийг, бусад эргэлтийн хөрөнгө 0.10, бусад хөрөнгө 0.26 хувийг тус тус эзэлснээр нийт хөрөнгийн 35.04 хувийг эргэлтийн хөрөнгө эзэлсэн байна.

Харин эсрэгээрээ эргэлтийн бус хөрөнгө нь нийт хөрөнгийн 64.96 хувийг эзэлж байх бөгөөд бүтэц нь дараах байдалтай байна. Нийт хөрөнгийн 54.5 хувийг үндсэн хөрөнгө, 0.66 хувийг биет бус хөрөнгө, 4.54 хувийг урт хугацаат хөрөнгө оруулалт, хайгуул ба үнэлгээний хөрөнгө 0,26 хувийг, 0.26 хувийг хойшлогдсон татварын хөрөнгө, бусад эргэлтийн бус хөрөнгө 5.15 хувийг тус тус эзэлж байна.

### Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн бүтэц:

Тайлант улирлын байдлаар эргэлтийн бус хөрөнгө нь нийт хөрөнгийн 16.38 хувийг эзэлж байх бөгөөд бүтцээр нь харвал нийт хөрөнгийн 7.52 хувийг дансны өглөг, 0.21 хувийг цалингийн өглөг, 1.05 хувийг татварын өр, 0,0 хувийг НДШ-ийн өглөг, 3.75 хувийг банкны богино хугацаат зээл, 0.31 хувийг хүүний өглөг, 0.73 хувийг ногдол ашгийн өглөг, 1.03 хувийг урьдчилж орсон орлого, бусад өр төлбөр 1.47 хувийг тус тус эзэлж байна.

Мөн урт хугацаат өр төлбөрийн дүн нь нийт хөрөнгийн 26.62 хувийг эзэлж байх бөгөөд нийт хөрөнгийн 19.34 хувийг урт хугацаат зээл эзэлж байгаа бол бусад урт хугацаат өр төлбөр нийт хөрөнгийн 7.28 хувийг эзэлж байна.

Харин эздийн өмчийн дүнгийн хувьд нийт хөрөнгийн 57.01 хувийг эзэлж байх бөгөөд задлавал дараах байдалтай байна. Нийт хөрөнгийн 17.28 хувийг төрийн хувьцаат капитал, 4.79 хувийг хувийн хувьцаат капитал, 0.01 хувийг халаасны хувьцаа, 1.38 хувийг нэмж төлөгдсөн капитал, 17.67 хувийг хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, эздийн өмчийн бусад хэсэг 15.61 хувийг, хуримтлагдсан ашиг 0.28 хувийг тус тус эзэлж байна.

### 2014 оны мөн үетэй харьцуулахад:

2014 оны эхний хагас жилээр 196 хувьцаат компани хагас жилийн санхүүгийн тайлангаа ирүүлж байсан бол 2015 оны эхний хагас жилээр 177 хувьцаат компани санхүүгийн тайлангаа тус Хороонд холбогдох хууль, журмын дагуу ирүүлсэн байна.

2015 оны хагас жилийн тайлангийн эргэлтийн хөрөнгийн дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 126 374 118.70 мян.төг буюу 8.73 хувиар, эргэлтийн бус хөрөнгийн дүн нь 668 717 968.60 мян.төг буюу 24.91 хувиар өссөн байна.

Мөн нийт хөрөнгийн дүн нь 795 092 087.30 мян.төг буюу 19.24 хувиар, өр төлбөрийн нийт дүн нь 76 726 482.20 мян.төг буюу 4.32 хувиар, эздийн өмчийн дүн нь 719 144 252.90 мян.төг буюу 30,52 хувиар тус тус өссөн.

Харин борлуулалтын орлого (цэвэр) нь 152 984 404 мян.төг буюу 16.31 хувиар, борлуулсан бүтээгдэхүүний өртөг нь 124 780 824.20 мян.төг буюу 15,53 хувиар, ерөнхий ба удирдлагын зардал нь 9 684 053.90 мян.төг буюу 11.77 хувиар өссөн бол тайлант үеийн цэвэр ашиг 3 492 594.10 мянган төгрөгийн ашигтай гарсан байх бөгөөд өмнөх оны мөн үе /-33 319 932.40 мян.төг/- тэй харьцуулахад 36 812 526.5 мян.төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Компанийн тухай хуулийн 31.3-т заасан компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан хувьцаат компаниудын тоо 49 байх бөгөөд уг хувьцаат компаниудын өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгөнөөс нийлбэр дүнгээр 131 828 928.20 мянган төгрөгөөр багассан үзүүлэлттэй байна.

### Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан компанийн тоо, бүртгэл:

Тайлант хугацаанд "Блюскай секьюритиз" ҮЦК ХК, "УБ БҮК" ХК, "БИНСЭ" ХК, "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК, "Хай Би Ойл" ХК, "ДБЭХСүлжээ" ТӨХК-иуд буюу нийт 6 хувьцаат компани нэмж хувьцаа гаргасан бол "Бишрэлт индастриэл" ХК, "Дорнод хүнс" ХК, "Монголын гэгээ" ХК, "Азиа пасифик пропертис" ХК, "Монгол мах экспо" ХК-иуд буюу нийт 5 хувьцаат компани нь нийтэд гаргасан хувьцаагаа үнэт цаасны бүртгэлээс хасуулсан байна.

Мөн тайлант хугацаанд "Баянбогд" ХК нь "Стандарт проперти групп" ХХК-тай нэгдэж, компанийн нэрийг "Стандарт проперти групп" ХК болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан байна.

"Дорнод импекс" ХК нь компанийн хувьцааныхаа арилжааг сэргээсэн бол "Шарын гол" ХК нь компанийн тодорхой хэмжээний хувьцааг бүртгэлээс хасуулсан байна.

Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан компаниудын талаарх мэдээллийг хүснэгтлэн харуулбал:

Хүснэгт - 15

№	Компанийн нэрс	Огноо	Тогтоолын дугаар	Тайлбар
1	"БИНСЭ" ХК	2015.01.28	70	1 сая хувьцааг нэмж бүртгэсэн
2	"Стандарт проперти групп" ХК /Баянбогд/	2015.04.01	162	Баянбогд ХК-ийг "Стандарт проперти групп" ХХК-тай нэгтгэн нэрийг "Стандарт проперти групп" ХК болгон өөрчлөн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан
3	"Блюскай секьюритиз" ҮЦК ХК	2015.05.20	243	1805054 ширхэг хувьцааг нэмж бүртгэсэн
4	"Дорнод хүнс" ХК	2015.05.20	256	Үнэт цаасны бүртгэлээс хассан
5	"Дорнод импекс" ХК	2015.06.24	285	Арилжааг нь сэргээсэн
6	"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК	2015.06.24	286	221280101 ширхэг хувьцааг нэмж бүртгэсэн
7	"Монголын гэгээ" ХК	2015.06.24	287	Үнэт цаасны бүртгэлээс хассан
8	"УБ БҮК" ХК		288	1775475 ширхэг хувьцааг нэмж бүртгэсэн
9	"Хай Би Ойл" ХК	2015.07.02	302	42884686 ширхэг хувьцааг нэмж бүртгэсэн

**СЗХ | Үнэт цаасны зах зээлийн тойм /2015 оны 2 дугаар улирал/**

10	"Шарын гол" ХК	2015.07.03	308	2015 оны 308 дугаар тогтоолоор ҮЦБ-д өөрчлөлт оруулж 61 147 ширхэгийг хассан
11	"Монгол мах экспо" ХК	2015.07.03	309	Үнэт цаасны бүртгэлээс хассан
12	"Бишрэлт индастриэл" ХК	2015.07.03	310	Үнэт цаасны бүртгэлээс хассан
13	"ДБЭХСүлжээ" ТӨХК	2015.07.03	311	62,679,220 ширхэг хувьцааг нэмж бүртгэсэн
14	"Азиа пасифик пропертис" ХК	2015.07.10	329	Үнэт цаасны бүртгэлээс хассан

**Ногдол ашиг тараалтын байдал:**

Тайлант хугацаанд нэр бүхий 23 хувьцаат компани нийт 199 854 730 ширхэг хувьцаанд ногдох нийт 7 313 698 806.5 төгрөгийн ногдол ашгийг тараахаар шийдвэрлэсэн байна. Үүнд:

Хүснэгт-16

Д/д	Компанийн нэрс	Нэгж хувьцаанд тараах ногдол ашгийн мөнгөн дүн	Нийт хувьцааны тоо ширхэг	Ногдол ашгийн нийт дүн	Бүртгэх өдөр	Тараах хэлбэр
1	Тахь Ко	82	1 189 983.0	97 578 606.0	2015.03.16	ҮЦТТХТ
2	Говь	140	7 801 125.0	1 092 157 500.0	2015.02.27	ХК, ҮЦТТХТ
3	Монинжбар	5	15 869 233.0	79 346 165.0	2015.03.03	ХК
4	Гермес центр	4.07	78 543 001.0	319 670 014.1	2015.02.28	ХК, ҮЦТТХТ
5	Бинсэ	10	1 268 320.0	12 683 200.0	2015.02.26	-
6	УБ БҮК	66	1 128 275.0	74 466 150.0	Ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр	ХК
7	Ариг гал	42.51	3 479 320.0	147 905 893.2	-	-
8	Эрдэнэт суврага	5	156 054.0	780 270.0	2015.03.02	ҮЦТТХТ
9	Баянтээг	100	252 608.0	25 260 800.0	2015.03.14	ҮЦТТХТ
10	Махимпекс	100	3 800 721.0	380 072 100.0	2015.03.26	ХК
11	Талх чихэр	120	1 023 703.0	122 844 360.0	2015.03.31	ХК
12	Газар сүлжмэл	13196.8	65 362.0	862 569 241.6	2015.02.20	ХК
13	Монголын цахилгаан холбоо	6.0637	25 870 276.0	156 869 592.6	2015.04.02	ҮЦТТХТ
14	Ган хэрлэн	300	99 899.0	29 969 700.0	-	-
15	Таван толгой	59	52 665 200.0	3 107 246 800.0	2015.03.09	ҮЦТТХТ, ХК
16	Тавилга	408	122 754.0	50 083 632.0	2015.04.02	ҮЦТТХТ, ХК
17	Адуунчулуун	85	3 151 304.0	267 860 840.0	2015.03.27	ҮЦТТХТ, ХК
18	Ган хийц	100	242 464.0		2015.03.05	ҮЦТТХТ, ХК
19	Хөвсгөл алтан дуулга	221.89	113 286.0		2015.03.23	-
20	Ачит алкабы	30	74 127.0	2 223 810.0	2015.03.10	-
21	Техник импорт	300	1 446 755.0	434 026 500.0	2015.03.16	ХК
22	Материал импекс	80	1 368 206.0		2015.02.24	ҮЦТТХТ
23	Тавилга	408	122 754.0	50 083 632.0	-	-
<b>НИЙТ</b>			<b>199 854 730.0</b>	<b>7 313 698 806.5</b>		

### Ногдол хувь тараалтын байдал:

Тайлант хугацаанд “Бишрэлт индастриэл” ХК, “Дорнод хүнс” ХК, “Монголын гэгээ” ХК, “Азиа пасифик пропертис” ХК-иуд буюу нийт 4 хувьцаат компани нь Хороонд холбогдох хууль, журмын дагуу хүсэлт гаргаж нийтэд гаргасан хувьцаагаа үнэт цаасны бүртгэлээс хасуулсан.

Харин 2015 оны 2 дугаар улирлын байдлаар “ҮЦТТТХТ” ХХК нь 1 хувьцаат компанитай ногдол хувийн гэрээ байгуулж, үйлчилгээний хөлс 667 000 төгрөг тооцож, нийт 1 274 харилцагчийн дансанд 123.9 сая төгрөгийн ногдол хувийн мөнгийг байршуулсан байна.

2014 оны 12 дугаар сарын 08-ны өдөр гэрээ байгуулж, үйлчилгээний хөлсөө төлсөн боловч гэрээнд заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол хувийн дутуу мөнгийг шилжүүлж дууссан тул “Хялганат” ХК-ийн 428 хувьцаа эзэмшигчийн 1 304 ширхэг хувьцаанд ногдох 30 407 428.32 төгрөгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсан байна.

Тайлант хугацаанд “ҮЦТТТХТ” ХХК-тай ногдол хувь тараах гэрээ байгуулан ногдол хувь тараасан хувьцаат компаниудын талаарх мэдээллийг хүснэгтлэн харуулбал:

Хүснэгт-17

№	Компанийн нэрс	Бүртгэх өдөр	Нэгж үнэ	ХЭ-ийн тоо	Хувьцааны тоо	Дансанд байршуулсан мөнгө	Дансанд байршуулсан огноо
1	“ХЯЛГАНАТ” ХК	2014/10/08	23319	428	1 304	30 407 428	2015/02/03
2	“ДОРНОД ХҮНС” ХК	2015/05/20	760	1 274	163 019	123 894 440	2015/05/28
<b>НИЙТ</b>				1 702	164 323	154 301 868	


### Их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцлийн судалгаа

Тайлант хугацаанд “Говь” ХК 20 тэрбум төгрөгийн, “Материал импекс” ХК 10 тэрбум төгрөгийн, “Атар өргөө” ХК 5.37 сая ам.долларын, “Хархорин” ХК 4.04 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус татахын тулд компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөр их хэмжээний хэлцлийг санал нэгтгэйгээр шийдвэрлүүлж тус Хорооноос холбогдох тодорхойлолтыг авсан байна.

### Засгийн газрын үнэт цаасны судалгаа:

2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хооронд нийт 2 933 904 ширхэг үнэт цаасыг 283.4 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 12, 28, 52, 156, 260 долоо хоногийн хугацаатай ЗГҮЦ хөрөнгийн биржээр тус тус арилжаалагдсан байна. Энэхүү ЗГҮЦ-ны өгөөжийн муруй дараах байдалтай байна. Үүнд:

График-14



ЗГҮЦ-ыг хугацааны хувьд ангилахад нийт үнийн дүнд эзлэх хувь дараах байдалтай байна. Үүнд:


График-15



Статистик мэдээллээс үзэхэд 12 долоо хоногтой ЗГҮЦ-ны арилжаа хамгийн их буюу 89.05 хувь /252.3 тэрбум төгрөг/-ийг эзэлж байна. 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд 12, 28, 52, 156, 260 долоо хоногийн хугацаатай, нийт 283.4 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжаалсан байна.

Монголбанкаар арилжаалсан ЗГҮЦ-ыг хугацааны хувьд ангилахад үнийн дүнд эзлэх хувь дараах байдалтай байна. Үүнд:

График-16



Статистик мэдээллээс үзэхэд 12 долоо хоногтой ЗГҮЦ-ны арилжаа хамгийн их буюу 59.64 хувь /507.5 тэрбум төгрөг/-ийг эзэлж байна. Монголбанкаар 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд 12, 28, 52, 156 долоо хоногийн хугацаатай, нийт 850.89 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжаалсан байна.

ЗГҮЦ-ны нийт арилжаалагдсан дүн 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 1,134.28 тэрбум төгрөг байх бөгөөд Монголбанк болон хөрөнгийн биржээр арилжагдсан ЗГҮЦ-ыг ангилан доорхи графикт харуулав. Үүнд:

Огноо	Монголбанк		"Монголын хөрөнгийн бирж" ХК	
	Тоо ширхэг	Үнийн дүн /сая ₮/	Тоо ширхэг	Үнийн дүн /сая ₮/
2015 оны 1 дүгээр улирал	364 000	345 635.12	1 255 949	108 077.30
2015 оны 2 дугаар улирал	531 500	505 256.96	1 677 955	175 088.75

Жич: Монголбанкны ЗГҮЦ-ны нэрлэсэн үнэ 1 сая төгрөг, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн ЗГҮЦ-ны нэрлэсэн үнэ 100 мян.төгрөг болно.

График-17



Нийт арилжаалагдсан ЗГҮЦ-ны эзлэх хувиар ангилахад Монголбанкар арилжсан ЗГҮЦ-ны эзлэх хувь 75.02, "Монголын хөрөнгийн бирж" ХК-иар арилжсан ЗГҮЦ-ны эзлэх хувь 24.98 байна.

### Шигтгээ-3:

- Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих шатанд төрөөс иргэдэд үнэ төлбөргүйгээр хөрөнгө оруулалтын эрхийн бичгийг тарааж, уг эрхийн бичгээр хувьчлагдсан аж ахуйн нэгжүүдийн хувьцааг эзэмшүүлснээр үнэт цаасны зах зээл дэх хөрөнгө оруулагчийн тогтолцоо бий болсон.
- Гэвч үнэт цаасны зах зээлийн талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэл дутмаг, мэргэжлийн зуучлагч байгууллагыг ёс зүйгүй үйлдэл, хувьцаат компанийн бүртгэлийн шаардлага хангалтгүй, үнэлгээ хэт доогуур байснаас шалтгаалан цөөн тооны этгээдүүдийн гарт дийлэнх хувьцаат компаниудын хяналтын багц төвлөрч, компанийн засаглал, ил тод байдал, тайлагналын зарчим алдагдагдахад голлох нөлөөг үзүүлсэн.
- Тус Хорооны зүгээс Компанийн засаглалын үндэсний зөвлөлтэй хамтран бүртгэлтэй хувьцаат компаниудын засаглалыг сайжруулах, төвлөрлийг сааруулах, 75 хувиас дээш төвлөрөлтэй хувьцаат компаниудыг биржийн бүртгэлээс хасах, төрийн өмчийн компаниудыг биржээр дамжуулан хувьчлах чиглэлд анхаарал хандуулан ажиллаж байна.

### 2.3. Зохицуулалттай этгээд:

2015 оны хагас жилийн байдлаар Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа явуулж буй арилжаа эрхлэх 2, төлбөр, тооцоо, хадгаламжийн 1, брокер, дилерийн 63 компани, мөнгөн хөрөнгийн төлбөр гүйцэтгэх 5 арилжааны банк, хөрөнгө оруулалтын менежментийн 2 компани, давхардсан тоогоор андеррайтерийн тусгай зөвшөөрөлтэй 24, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх 15, кастодиан үйлчилгээ үзүүлэх арилжааны 3 банк байна.

Тайлант хугацаанд Хорооноос тусгай зөвшөөрөл олгосон үнэт цаасны компани 63, арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банк 3, хөрөнгө оруулалтын менежментийн 3, нийт 72 зохицуулалттай этгээд үйл ажиллагаа явуулж байна.

Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай этгээдүүдийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт-19

Д/д	Тусгай зөвшөөрлийн төрлөөр	Зуучлагч байгууллагын тоо
1	Арилжаа эрхлэх	2
2	Төлбөр тооцоо, хадгаламжийн	1
3	Харилцагчийн нэрийн өмнөөс зуучлалын үйлчилгээ үзүүлэх	11
4	Хөрөнгө оруулалтын менежментийн	3
5	Брокер, дилерийн	63
6	Кастодианы үйлчилгээ үзүүлэх	3
7	Давхардсан тоогоор андеррайтерийн	24
8	Давхардсан тоогоор хөрөнгө оруулалтын зөвлөхийн	15
	<b>НИЙТ</b>	<b>72</b>

Хорооны 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 312 дугаар тогтоолоор “Дилерийн арилжааны төв” ХХК-д үнэт цаасны арилжаа эрхлэх, үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Монгол улсын хувьд 2 дахь бирж байгуулагдсан энэхүү үйл явдал нь зах зээлийн өрсөлдөөнийг бий болгож, үйлчилгээний зардлыг бууруулах, ингэснээр зах зээлд оролцогчдод эерэгээр нөлөөлөх давуу талтай байна.

Тайлант хугацаанд “Юнайтед секьюритиз ҮЦК” ХХК-ийн брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооны 2015 оны 73 дугаар тогтоолоор түдгэлзүүлж, “Голомт секьюритиз ҮЦК” ХХК-д андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2015 оны 156 дугаар тогтоолоор нэмж олгосон.

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-д нийт 62 ҮЦК бүртгэлтэй байгаагаас тайлант хугацаанд 43 компани үнэт цаасны арилжаанд оролцож гүйлгээ хийсэн байна. Үүнээс Засгийн газрын бондын арилжаанд “Тэнгэр капитал” ХХК, “Ти Ди Би Капитал” ХХК, “Ард капитал групп” ХХК, “Голомт секьюритис” ХХК, “Би Ди Сек” ХХК, “Дэу секьюритис Монгол” ХХК-иуд хамгийн их гүйлгээг хийжээ. Хувьцааны арилжаанд “Би Ди Сек” ХК, “Монгол секьюритис” ХХК, “Стандарт инвестмент” ХХК-иуд тус тус хамгийн их үнийн дүн бүхий арилжааг гүйцэтгэсэн байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 54.1-д “Зохицуулалттай этгээд нь тухайн санхүүгийн тайлангийн жил дуусах тухай бүр нягтлан бодох болон бусад бүртгэлдээ аудитийн шалгалт хийлгэж, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан хувийг аудитийн дүгнэлтийн хамт Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлнэ” гэж заасны дагуу давхардсан тоогоор Хороонд бүртгэлтэй нийт 63 брокер дилер, 24 андеррайтерийн компаниас 47 компани санхүүгийн тайлангаа ирүүлсэн байна.

**Жич:** “Голомт банк” ХХК нь зөвхөн андеррайтерийн тусгай зөвшөөрөлтэй, санхүүгийн тайлангийн хувьд хэт өндөр дүнтэй учир салбарын нэгтгэл дэх үзүүлэлтүүдийг хий нэмэгдүүлэхээр байсан тул тайлангийн нэгтгэлд оруулаагүй болно.

### **Нийт активын бүтэц:**

2015 оны 2 дугаар улирлын байдлаар нэгтгэлд хамрагдсан 47 үнэт цаасны компаниудын нийт актив хөрөнгө 67.6 тэрбум төгрөг байх бөгөөд тайлант улирлын байдлаар мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нийт активын 41.04 хувийг, авлага нийт активын 7.45 хувийг, бараа материал, урьдчилж төлсөн зардал нийт активын 0.93 хувийг, богино хугацаат хөрөнгө оруулалт 18.91 хувийг, бараа материал 0.93 хувийг, үндсэн хөрөнгө 11.06 хувийг бусад үндсэн хөрөнгө 1.34 хувийг, бусад эргэлтийн бус хөрөнгө 0.20 хувийг тус тус эзэлж байна.

### **Пассивын бүтэц:**

Харин пассивын бүтцийн хувьд тайлант улирлаар мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нийт активын 64.74 хувийг, авлага нийт активын 7.45 хувийг, бараа материал, урьдчилж төлсөн зардал нийт активын 37.36 хувийг, богино хугацаат хөрөнгө оруулалт 25.79 хувийг, бараа материал 0.93 хувийг, үндсэн хөрөнгө 11.06 хувийг бусад үндсэн хөрөнгө 1.34 хувийг, бусад эргэлтийн бус хөрөнгө 12.16 хувийг тус тус эзэлж байна.

### **Ашигт ажиллагаа:**

2015 оны 02 дугаар улирлын байдлаар системийн нэгтгэлийн үзүүлэлт 385.7 сая төгрөгийн цэвэр ашигтай гарсан байх бөгөөд өмнөх оны мөн үе /-812.42 сая төгрөг/-тэй харьцуулахад 1 198.21 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд нэр бүхий 19 үнэт цаасны компани үйл ажиллагаа явуулаагүй, арилжаанд оролцоогүй байна.

